

ТАНИЛЦУУЛГА

Цахим орчинд хүүхдийн эрхийг
хамгаалах тухай хуулийн төслийн талаар

Мэдээлэл, харилцаа холбооны хурдацтай хөгжил түүнийг даган хувьсаж байгаа нийгмийн өөрчлөлтөд цахимд суурилсан хэрэглээ тэргүүлэх болсон бөгөөд үүнийг нийгмийн харилцааны бүхий л оролцогчид дэмжсээр ирсэн.

Харин сүүлийн үед цахим орчныг хүний эрхтэй холбон авч үзэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор цахим орчинд эрх зүйн зохицуулалт хийх, тодорхой хязгаарлалт тогтоох үйл явц өрнөх болсон.

Цахим орчныг интернэт ашиглагч (хэрэглэгч-хөгжүүлэгч) хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, төрийн байгууллага болон олон улсын байгууллага, улс орнууд өөрсдийн үйл ажиллагааны зорилго, онцлогт нийцсэн техник хэрэгсэл, программын тусламжтайгаар бүрдүүлж хөгжүүлсээр байгаа бөгөөд тус орчин нь хил хязгаар, орон зай, цаг хугацаанаас үл хамаардаг. Хувийн хэрэгцээ болон ахуйн хэрэглээний гар утас, телевиз, цаг, компьютер, таблет, автомашин, аюулгүй байдлын тоног төхөөрөмж зэрэг өдөр тутмын идэвхитэй хэрэглээний бүхий л зүйлс цахим орчинтой ямар ч саад бэрхшээлгүйгээр холбогдохын зэрэгцээ, интернэтээс шууд хамааралтай болсон нь хүний тэр дундаа хүүхдийн хүмүүжил, ёс суртахуун, эрх, эрх чөлөө, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Цахим орчны хөгжил хүүхдэд гүнзгий нөлөөлөх болсны сөрөг тал нь цахим дээрэлхэл, гадуурхал, гүтгэлэг, доромжлол, хууль бус контент, сурталчилгаанд өртөх зэрэг байдлаар илэрч, улмаар энэ нь донтох, ёс суртахуун, хүмүүжлийн доголдолтой болох, сэтгэл гутралд орох, эцэст нь амиа хорлоход хүргэх зэрэг тодорхой үр дагаврыг хүүхдэд бий болгох болсон тул цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах асуудалд онцгойлон анхаарал хандуулах шаардлагыг бий болгосон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр булийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана. Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна” гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохицтой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтооюулж батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд “Цахим орчинд хүний эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх”-ээр тусгасан.

Энэхүү хуулийн төслийн зорилт нь цахим орчинд хүүхдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг цахим дарамт, заналхийлэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны тогтолцоо, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан. Үүнд:

1. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах талаар Монгол Улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбоотой харилцаа;

2. Цахим орчин дахь мэдээлэлд хандах, нэвтрүүлэх, дамжуулах болон хүлээн авах зорилгоор хэрэглэх мэдээллийн системийн үйлчилгээ эрхэлж буй болон тэдгээрт мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэгч этгээдийн эрх, үүргийг тодорхойлохтой холбоотой харилцаа;

3. Цахим орчин дахь хүүхдийн мэдээллийн аюулгүй байдал алдагдаж болох эрсдэл түүнээс үүсэх үр дагаварыг бууруулах, урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцаа;

5. Цахим орчин дахь хүүхдийн эрхийн халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хуульчлахтай холбоотой харилцаа;

6. Цахим орчинд хүүхдийн эрхийг зөрчиж байгаа талаар гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэхтэй холбоотой харилцааг тус тус зохицуулсан байна.

Хуулийн төсөлд тусгасан шинэлэг зохицуулалт бүхий харилцаа нь цахим орчин дахь хүүхдийн мэдээллийн аюулгүй байдал, цахим заналхийлэл, цахим дарамтыг олон улсын жишгийн дагуу тодорхойлж, гэр бүл, боловсрол, сургалтын байгууллага болон цахим сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг хуульчилсан.

Иймд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах нь үндэсний хэмжээнд авч үзэх асуудал бөгөөд төр, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тусгах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянан зохицуулах нэгдсэн удирдлагаар хангах тогтолцоог бэхжүүлж өгсөнд энэ хуулийн ач холбогдол оршино гэж үзэж байна.

Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна

---00---